



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/04/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261628 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Болор-Эрдэнэ
Утас: 261740 Цахим хаяг: bolor-erdened@audit.gov.mn
Гэрээт аудитор: О.Наранбат
Утас: 261740 Цахим хаяг: naranbato@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга	11
3.5.1 Мөнгөн хөрөнгө	11
3.5.2 Авлага	12
3.5.3 Урьдчилгаа	13
3.5.4 Бараа материал	14
3.5.5 Үндсэн хөрөнгө	14
3.5.6 Өр төлбөр	15
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо	16
3.5.8 Орлогын данс	16
3.5.9 Зардлын данс	17
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	18
3.8 Аудитын гол асуудал	18
3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт	20
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
4. Аудитын илрүүлэлт	20
4.1 Харьяа байгууллагууд	20
4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч	21
4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулсан алдаа	21
4.2.2 Төлбөрийн акт	21
4.2.3. Албан шаардлага	22
4.2.4 Зөвлөмж	25
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	26
5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл	26
5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл	28

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ЗГБНҮГ	Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ӨХБЗ	Өмч хамгаалах байнгын зөвлөл
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТӨААТҮГ	Төрийн өмчийн аж ахуйн тооцоот төрийн үйлчилгээний газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТШЗ	Төсвийн шууд захирагч
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
УБОУНОШБ	Улаанбаатар хотын Олон Улсын нисэх онгоцны шинэ буудал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ХОҮХ	Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ИНҮТ	Иргэний нисэхийн үндэсний төв
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА С.МӨНХНАСАН

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.03.25 № 01/718
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийж гүйцэтгэлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Иргэний нисэхийн ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар залруулагдаагүй 3,745.0 сая төгрөгийн зөрчил илэрч, тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.3, 5.1.5, 6.4.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйл 46.1.4, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх заалт, Нийцсэн бөгөөд зохистой байх, Эрх ба үүрэг, Тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	183,115,573.8	152,331,508.7
31	Мөнгөн хөрөнгө	92,803,614.6	31,964,743.2
33	Авлага	70,866,379.0	70,668,580.0
34	Урьдчилж төлсөн зардал	547,960.8	1,011,364.7
35	Бараа материал	18,892,072.0	23,846,129.3
360	Бусад эргэлтийн хөрөнгө	5,547.5	24,840,691.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,905,503,815.9	1,878,219,156.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,905,503,815.9	1,878,219,156.8
39200	Биет хөрөнгө	1,281,632,559.3	1,379,002,164.3
39300	Биет бус хөрөнгө	464,229,700.0	466,237,401.1
39400	Хойшлогдсон татварын хөрөнгө	3,984,770.7	4,464,797.6
39500	Дуусаагүй барилга	155,656,785.8	28,514,793.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,088,619,389.6	2,030,550,665.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	18,154,157.7	30,176,803.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,979,978.8	6,707,228.3
41300	Өглөг	8,852,153.3	6,670,853.8
41400	Урьдчилж орсон орлого	127,825.5	36,374.5
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,174,178.9	23,469,575.3
42229	Хойшлогдсон татварын өглөг	2,489,831.0	3,066,802.8
42242	Урьдчилж орсон орлого /ХО/	6,684,347.8	20,402,772.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,070,465,232.0	2,000,373,861.8
51	Засгийн газрын хувь оролцоо	2,070,465,232.0	2,000,373,861.8
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,947,351,547.0	1,972,186,690.9
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	32,584,973.3	32,207,883.0
51200	Хуримтлагдсан үр дүн	90,528,711.7	(4,020,712.0)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,088,619,389.6	2,030,550,665.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	206,784,992.1	199,636,766.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	203,696,406.8	199,636,766.4
120	Нийтлэг татварын бус орлого	203,696,406.8	196,654,065.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,088,585.3	2,982,700.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	214,779,089.5	279,269,586.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	214,779,089.5	279,269,586.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	139,779,089.5	156,391,150.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	79,352,255.4	70,043,648.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,259,801.4	9,345,858.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,054,239.4	6,035,058.5
2104	Хангамж, бараа материалын зардал	5,248,039.7	5,023,778.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,338,447.7	2,879,002.4
2107	Томилолт, зочны зардал	737,055.5	559,249.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,789,250.4	62,504,553.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,000,000.0	122,878,436.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(7,994,097.4)	(79,632,819.9)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	11,840,696.2	4,669,811.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11,685,095.9	9,555,143.2
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(7,838,497.1)	(84,518,151.6)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,086,935,229.6	780,705,767.6
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,086,935,229.6	2,086,935,229.6
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(27,682.8)	(27,682.8)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	(8,251,740.4)	(8,251,740.4)
Эздийн өмчийн бусад хэсэг	(352,077.3)	(352,077.3)
Тайлант үеийн үр дүн	(7,838,497.1)	(7,838,497.1)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,070,465,232.0	2,070,465,232.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,070,465,232.0	2,070,465,232.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	(10,031,272.1)	(10,031,272.1)
Эздийн өмчийн бусад хэсэг	24,458,053.6	24,458,053.6
Тайлант үеийн үр дүн	(84,518,151.6)	(84,518,151.6)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,000,373,861.8	2,000,373,861.8

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	226,998,396.9	197,408,393.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	223,909,811.6	194,354,800.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,088,585.3	3,053,592.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	219,461,219.4	249,756,478.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	219,461,219.4	249,756,478.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	80,436,517.4	70,402,073.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,018,005.3	9,379,719.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,494,310.7	3,542,804.8
2104	Хангамж, бараа материалын зардал	4,324,203.2	3,729,211.0
2105	Нормативт зардал	229,458.8	142,817.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,149,277.9	4,146,749.1
2107	Томилолт, зочны зардал	700,791.6	526,259.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,319,380.7	24,012,871.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,406,267.1	4,608,186.0
212	ТАТААС	350,852.0	88,011.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,032,154.7	129,177,775.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	7,537,177.5	(52,348,085.1)
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	27,104,812.2	8,075,904.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(27,104,812.2)	(8,075,904.9)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	(414,881.4)
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	414,881.4
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(19,567,634.7)	(60,838,871.4)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	112,371,249.3	92,803,614.6
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	92,803,614.6	31,964,743.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувиар
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	3,053,592,900.00	2,982,700,609.05	70,892,290.95	97.7
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	3,053,592,900.00	2,982,700,609.05	70,892,290.95	97.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,879,788,300.00	2,808,896,009.05	70,892,290.95	97.5
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,341,082,000.00	2,341,081,999.91	0.09	100.0
Үндсэн цалин	2,004,002,500.00	2,004,002,499.91	0.09	100.0
Нэмэгдэл, урамшил	202,315,800.00	202,315,800.00	-	100.0
Унаа, хоолны хөнгөлөлт	134,763,700.00	134,763,700.00	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	316,046,100.00	316,046,100.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,727,300.00	64,377,840.36	13,349,459.64	82.8
Гэрэл цахилгаан	24,135,300.00	21,350,460.36	2,784,839.64	88.5
Түлш, халаалт	36,432,000.00	28,462,500.00	7,969,500.00	78.1
Цэвэр, бохир ус	17,160,000.00	14,564,880.00	2,595,120.00	84.9
Хангамж, бараа материалын зардал	25,320,800.00	22,802,268.78	2,518,531.22	90.1
Бичиг хэрэг	10,258,600.00	7,741,900.00	2,516,700.00	75.5
Тээвэр (шатахуун)	4,908,400.00	4,908,400.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,639,400.00	3,638,968.78	431.22	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс	6,514,400.00	6,513,000.00	1,400.00	100.0
Нормативт зардал	7,837,900.00	-	7,837,900.00	-
Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,837,900.00	-	7,837,900.00	-
Эд хогшил, урсгал засварын зардал	6,522,800.00	-	6,522,800.00	-
Багаж, техник хэрэгсэл	3,676,600.00	-	3,676,600.00	-
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,846,200.00	-	2,846,200.00	-
Томилолт, зочны зардал	624,000.00	624,000.00	-	100.0
Дотоод албан томилолт	624,000.00	624,000.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,464,000.00	22,800,800.00	40,663,200.00	35.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,700,000.00	-	29,700,000.00	-
Даатгалын үйлчилгээ	10,146,500.00	-	10,146,500.00	-
Тээврийн хэрэгслийн татвар	247,500.00	-	247,500.00	-
Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	-	99,000.00	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээний зардал	21,799,200.00	21,799,200.00	-	100.0
Газрын төлбөр	1,138,700.00	1,001,600.00	137,100.00	88.0
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	333,100.00	-	333,100.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	41,163,400.00	41,163,000.00	400.00	100.0
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	41,163,400.00	41,163,000.00	400.00	100.0
ТАТААС, УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	173,804,600.00	173,804,600.00	-	100.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг	171,315,000.00	171,315,000.00	-	100.0
Олон улсын байгууллагын гишүүний татвар	171,315,000.00	171,315,000.00	-	-
Бусад урсгал шилжүүлэг	2,489,600.00	2,489,600.00	-	100.0
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	2,489,600.00	2,489,600.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,053,592,900.00	2,982,700,609.05	70,892,290.95	97.7
Төсвөөс санхүүжих	3,053,592,900.00	2,982,700,609.05	70,892,290.95	97.7
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСАД БҮГД	106	106	-	100.0
Удирдах ажилтан	2	2	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	96	96	-	100.0
Үйлчлэх ажилтан	8	8	-	100.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төрийн өмчийн эд хөрөнгийн шилжилт хөдөлгөөн, ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох, зардлын ангиллын бүртгэлийн талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Д.Болор-Эрдэнэ, гэрээт аудитор О.Наранбат нар 2022 оны 3 дугаар сарын 05-ны өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн хооронд гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, Аудитын хоёрдугаар газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Сарансүх нар хэрэгжүүлсэн.

Иргэний нисэхийн ерөнхий газар 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/294 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны зорилго нь иргэний нисэхийн болон нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалт хийх, нислэгийн хөдөлгөөний удирдлага, холбоо, навигацийн техник тоног төхөөрөмж, мэдээлэл хангалт, нисэх буудал, газрын тусгай үйлчилгээ үзүүлж, үндэсний эдийн засагт хувь нэмэр оруулахад оршино.

Иргэний нисэхийн тухай хуулиар олгосон эрхийн дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн хувьд төрөөс иргэний нисэхийн талаар зайлшгүй хэрэгжүүлэх дараах чиг үүрэг, үйлчилгээг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр тусгасан асуудлыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;
- Иргэний нисэхийн талаарх Монгол Улсын Олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллах;
- Агаарын хөлөгт нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ үзүүлэх;
- Агаарын хөлгийн нислэгт холбоо навигацийн хангалт үйлчилгээ үзүүлэх;
- Нисэх буудлын газрын тусгай үйлчилгээ үзүүлэх;
- Иргэний нисэхийн салбарт нисэхийн болон нислэгийн аюулгүй байдлыг хангасан үйлчилгээ үзүүлэх;
- Мэргэжлийн туслалцаа үзүүлэх, мэргэжлийн сургалтыг зохион байгуулах;
- Төрийн захиргааны төв байгууллагаас шилжүүлсэн эрхийг хэрэгжүүлэх;
- Иргэний агаарын хөлгийг улсын бүртгэлд бүртгэх, бүртгэлийн гэрчилгээ олгох;
- Иргэний нисэхэд дагаж мөрдөх стандарт, заавар, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг хангах зэрэг үндсэн үүргүүдийг хэрэгжүүлдэг байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль тогтоомж, бодлого, чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2021 оны “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” 190 дүгээр тушаал;

- Иргэний нисэхийн ерөнхий газрын 2021 оны “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг шинэчлэн батлах тухай” А/124 дүгээр тушаал.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын Дотоод аудитын алба нь 2021 онд батлагдсан төлөвлөгөөний дагуу ерөнхий газар болон түүний харьяа 20 алба, салбар, хэлтэс нэгжид төлөвлөгөөт 44 удаагийн хяналт, шалгалтыг бүрэн хийж гүйцэтгэн, дотоод аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 277 зөвлөмж хүргүүлэн ажиллаж, хэрэгжилт 83.0 хувьтай үнэлэгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил, гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 288,356.2 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,883.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 58,068.7 сая төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, урьдчилж төлсөн зардал, бараа материал, дуусаагүй барилга, урьдчилж орсон орлого дансууд байна.

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 31,964.7 сая төгрөг болж, 60,838.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	1,479.4	1,277.9	(201.6)
Банканд байгаа бэлэн мөнгө	92,800,421.2	31,908,407.4	(60,892,013.8)
Замд яваа мөнгөн хөрөнгө	1,714.0	55,057.9	53,344.0
Дүн	92,803,614.6	31,964,743.2	(60,838,871.4)

Эх сурвалж: ИНЕГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 432.7 сая төгрөг хөрөнгө оруулалтын ажлын барьцаа болон техник хяналтын зардал Төрийн сангийн харилцах дансанд, 6,708.2 сая төгрөг арилжааны банкны дансанд, 24,768.8 сая төгрөг гадаад валютын дансанд тус тус байршиж байна.

Замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд Завхан аймгийн Отгонтэнгэр нисэх буудлын санхүүжилттэй холбоотой 54.0 сая, Сэргээн засах амралтын газрын орлого 1.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдлээс төлбөр тооцооны системийн доголдлоос шалтгаалан гүйлгээ хийх боломжгүй болсон Чингис хаан банканд 2,767.0 сая төгрөг байршиж байна.

Аудитын илрүүлэлт

- ИНУТ тайлант онд шүүхийн тогтоолоор нийт 14.9 сая төгрөгийн ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг нэр бүхий дөрвөн ажилтанд олгосон боловч байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлээгүй;

- ИНУТ-ийн хэмжээнд ажлын цагийг нэгтгэн тооцох заавар, аргачлал, тооцооллын нэгдсэн хүснэгт байхгүйгээс цагийн нэгтгэлийг буруу хийх, цалингийн тооцооллын алдаа гарах эрсдэлтэй;

- Говь-Алтай аймаг дахь "Алтай" нисэх буудал тайлант онд олговол зохих нийт цалингийн зардал, татварын тайлангийн татвар ногдох цалингийн орлогоос 0.7 сая төгрөгөөр зөрүүтэй;

- Ховд аймаг дахь нисэх буудал үр дүнгийн урамшууллыг сар бүр байгууллагын дарга, нягтлан бодогчид 12.4 сая төгрөг олгосон, байгууллагын даргад сар бүр утасны төлбөр 0.03 сая төгрөг олгосон;

- Ховд аймаг дахь нисэх буудал дотоод хяналтын ажлын төлөвлөгөөнд санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг тусгаагүй, томилолтын мөнгө олгохдоо анхан шатны баримт хангалтгүй, томилолтын хуудсыг байгууллагын удирдлагаар хаалт хийлгээгүй, ирсэн буцсан өдөр засвартай, бэлтгэн нийлүүлэгчээс худалдан авсан бараа, ажил, үйлчилгээ нь анхан шатны баримтаар баталгаажгаагүй, тайлант онд хамтран ажиллах гэрээ, бусад холбогдох баримтгүй үнс зайлуулсны ажлын 92.1 сая төгрөгийн хөлс олгосон;

- Ховд аймаг дахь нисэх буудал тайлант онд нэр бүхий ажилчдыг томилолтоор ажилласныг нотлох баримтгүй томилолтын мөнгө, тушаал, шийдвэргүй нэмэгдэл цалин 6.5 сая төгрөг олгосон.

3.5.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 70,668.6 сая төгрөг болж, 197.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	68,378.8	17,147.2	(51,231.6)
Дансны авлага /ТӨҮГ/	35,381,553.6	32,020,881.2	(3,360,672.4)
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	5,967,241.5	4,364,723.8	(1,602,517.6)
Байгууллагаас авах авлага	29,449,205.0	34,265,827.7	4,816,622.7
Дүн	70,866,379.0	70,668,580.0	(197,799.0)

Эх сурвалж: ИНЕГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэл буурсан нь гадаад, дотоодын авиа компаниудаас авах авлагыг тухайн улсын шүүхийн шийдвэр, тогтоолыг үндэслэн чөлөөлсөнтэй холбоотой байна.

Олон жилийн насжилттай, хугацаа хэтэрсэн авлага 4,743.3 сая төгрөг болж, өмнөх оноос 10,386.0 сая төгрөгөөр буурсан нь дараах шалтгаантай байна. Тухайлбал:

- МУЗГ-ын 2021 оны "МИАТ ТӨХК-ийн талаар авах арга хэмжээний тухай" 370 дугаар тогтоол, ЗТХС-ын 2021 оны 01/6006 дугаар албан бичиг, ИНЕГ-ын 2022 оны А/02 дугаар тушаалаар МИАТ ТӨХК-аас авах 11,732.1 сая төгрөгийн авлагаас 9,273.3 сая төгрөгийн навигаци, буулт хөөрөлт, газрын үйлчилгээний төлбөрийг;
- МУЗГ-ын 2020 оны "Агаарын тээврийн салбарт авах зарим арга хэмжээний тухай" 137 дугаар тогтоол, ЗТХС-ын 2020 оны 01/3866, Сангийн яамны ТНБД-ын 2021 оны 4-2/2778 дугаар албан бичиг, ИНЕГ-ын 2021 оны А/151 дүгээр тушаалаар дотоодын 3 авиа компаниас авах авлагаас 67.8 сая төгрөгийн навигацийн үйлчилгээний төлбөрийг;
- ИНЕГ-ын даргын зөвлөлийн 2021 оны 12/03 дугаар шийдвэр, ИНЕГ-ын 2022 оны А/04 дүгээр тушаалаар Аэромонголиа ХХК-аас авах 1,942.8 сая төгрөгийн авлагаас 759.6 сая төгрөгийн навигацийн үйлчилгээний төлбөрийг тус тус чөлөөлсөн;
- ИНЕГ-ын 2022 оны А/03 дугаар тушаалаар гадаадын 3 авиа компаниас авах хуримтлагдсан авлага 286.0 сая төгрөгийг тухайн улсын шүүхийн шийдвэрээр дампуурсан нь нотлогдсон тул данснаас хассан.

Нийт авлага дансны үлдэгдэлд дуусаагүй барилга болон улсын төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой 32,514.2 сая төгрөг, гадаад, дотоодын агаарын тээвэрлэгчидтэй холбоотой 32,020.9 сая төгрөгийн үйлчилгээний төлбөрийн авлага эзэлж байна.

Аудитын илрүүлэлт

- ИНУТ зохион байгуулалтын бүтцээр шилжиж байгаа болон ажлаас чөлөөлөгдөж байгаа ажилчидтай тойрох хуудсаар тооцоо хийгээгүйгээс эзэн холбогдогчгүй авлага үүсгэсэн;
- Говь-Алтай аймаг дахь "Алтай" нисэх буудал татварын тодорхойлолтоор 0.08 сая төгрөгийн дутуу, 1.3 сая төгрөгийн илүү төлөлттэй боловч санхүүгийн тайланд тусгаагүй;
- Говь-Алтай аймаг дахь "Алтай" нисэх буудал тайлант оны эцэст санхүүгийн тайланд тусгасан 3.1 сая төгрөгийн авлага 1.5 сая төгрөгийн өглөгийг барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулаагүй;
- Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудал нэгээс дээш жилийн насжилттай Аэро Монголиа ХХК-аас авах 2.0 сая төгрөг, Хүннү Эйр ХХК-аас авах 4.6 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй;
- Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал тайлант хугацаанд 21 байгууллага, хувь хүний 27.1 сая төгрөгийн авлага тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 1,011.4 сая төгрөг болж, 463.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	361,601.3	992,670.4	631,069.1
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	58,012.3	-	(58,012.3)
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	127,196.2	18,644.3	(108,551.9)
Томилолтын урьдчилгаа	1,151.0	50.0	(1,101.0)
Дүн	547,960.8	1,011,364.7	463,403.9

Эх сурвалж: ИНЕГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 670.3 сая төгрөг буюу 66.3 хувийг даатгалын, 118.8 сая төгрөг буюу 11.7 хувийг гадаад сургалтын, 101.1 сая төгрөг буюу 10.0 хувийг биет бус хөрөнгө бэлтгэх зардал тус тус эзэлж байна. Тухайлбал:

- Ард даатгал ХХК-тай байгуулсан Олон Улсын өнгөрөлтийн нислэгт үзүүлэх навигацийн үйлчилгээний явцад гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагын даатгалын 297.5 сая төгрөг;
- Бодь даатгал ХХК-тай байгуулсан барилга байгууламжийн даатгалын 79.9 сая төгрөг;
- Миг даатгал ХХК-тай байгуулсан Агаарын навигацийн нислэгийн удирдагч болон нисэхийн аюулгүй ажиллагааны байцаагч нарын эрүүл мэндийн даатгалын 179.2 сая төгрөг;
- Практикал даатгал ХХК-тай байгуулсан тоног төхөөрөмж, ажиллагсдын хариуцлага, гэнэтийн осол, тээврийн хэрэгслийн даатгалын 113.7 сая төгрөг;
- Тайланд улсад зохион байгуулагдах Нислэгийн удирдагч нарын сургалтын төлбөр 118.8 сая төгрөг;
- Антивирусын программ болон CISCO IC, ATIS, АФТН, НМҮА-ны автомат системийн техник үйлчилгээний 101.1 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг урьдчилж төлсөн.

Өмнөх оны үлдэгдлээс 108.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгааг тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт

- ИНУТ нэр бүхий 9 ажилтанд олгосон нэгээс дээш жилийн насжилттай урьдчилгаа цалингийн 3.2 сая, нэр бүхий ажилтны илүү цагийн тооцооллын алдаанаас үүссэн 0.4 сая, ажлаас гарсан нэр бүхий 13 ажилтны ээлжийн амралтын тооцоог хийгээгүйгээс үүссэн 6.7 сая, нэр бүхий ажилтны дараа тооцогоор үүссэн шатахууны 0.4 сая, нийт 10.6 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй;
- Баянхонгор аймаг дахь нисэх буудлын дараагийн тайлант хугацаанд хүлээн зөвшөөрөгдөх тээврийн хэрэгслийн даатгалын 1.6 сая төгрөгийг урьдчилж төлсөн зардал дансанд бүртгээгүй байна;
- Ховд аймаг дахь нисэх буудал Булган сумын техникч ээлжийн амралттай хугацаанд тухайн үед томилолтоор ажилласан хугацааны томилолтын 1.5 сая төгрөгийг олгоогүй;
- Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал тайлант хугацаанд 291 ажилтны ээлжийн амралтын тооцоог бодож олгохдоо амралтын хоногт 74.1 сая төгрөгийн хоолны нөхөн олговрыг тооцсон.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 23,846.1 сая төгрөг болж, 4,954.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	123,038.3	124,787.8	1,749.6
Дуусаагүй үйлдвэрлэл	5,162.3	10,772.8	5,610.5
Бэлэн бүтээгдэхүүн	148,780.7	194,844.5	46,063.8
Аж ахуйн материал	1,108,509.9	1,554,379.8	445,869.9
Сэлбэг хэрэгсэл	15,575,609.4	15,198,134.1	(377,475.3)
Түлш, шатах тослох материал	1,699,635.3	6,461,041.5	4,761,406.2
Бусад хангамжийн материал	231,336.1	302,168.7	70,832.6
Дүн	18,892,072.0	23,846,129.3	4,954,057.4

Эх сурвалж: ИНЕГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 4,954.0 сая төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2019 оны 382 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын Олон Улсын шинэ нисэх онгоцны буудлын хөрөнгөөс ТС1 төрлийн шатахууныг түлш, шатах тослох материалын зардалд хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд худалдан авсан бараа материал 24,253.2 сая, үнэ төлбөргүй шилжүүлэн авч бүртгэсэн 5,273.1 сая төгрөгөөр нэмэгдэж, 19,299.2 сая төгрөгийн зарцуулалттай байна.

Бараа материалын үлдэгдлийн 63.7 хувь буюу 15,198.1 сая төгрөг нь агаарын навигацийн үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэгийн үлдэгдэл байна.

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 24,835.1 сая төгрөгөөр өссөн нь Улаанбаатар хотын Олон Улсын шинэ нисэх онгоцны буудал барих төслийн хаалтын баланстай холбоотой хөрөнгийн бүртгэлээс шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт

- Тайлант хугацаанд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээ нь төлбөрийн 26.3 сая төгрөгийг и-баримтаар баталгаажуулж, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй; / Баянхонгор аймаг дахь нисэх буудал, Ховд аймаг дахь нисэх буудал/

- Ховд аймаг дахь нисэх буудал шатахууны урамшуулал бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас олгосон ч эд хариуцагч нь 3.2 сая төгрөгийг бараа материалын тайланд орлогоор бүртгээгүй.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,878,219.2 сая төгрөг болж, 27,284.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	1,052,458,549.7	1,163,676,053.5	111,217,503.8
Авто тээврийн хэрэгсэл	69,162,999.4	65,318,001.6	(3,844,997.8)
Машин, тоног төхөөрөмж	156,796,829.2	147,123,412.2	(9,673,417.0)
Тавилга, аж ахуйн эд хогшил	3,214,181.1	2,884,697.0	(329,484.0)
Дуусаагүй барилга, байгууламж	155,656,785.8	28,514,793.7	(127,141,992.1)
Биет бус хөрөнгө	464,229,700.0	466,237,401.1	2,007,701.1
Хойшлогдсон татварын хөрөнгө	3,984,770.7	4,464,797.6	480,027.0
Дүн	1,905,503,815.9	1,878,219,156.8	(27,284,659.1)

Эх сурвалж: ИНЕГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан нь авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, дуусаагүй барилга дансны бүртгэлээс голлон шалтгаалсан байна. Тухайлбал:

Үндсэн хөрөнгийн орлого:

- ТӨБЗГ-ын 2021 оны 152 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 20,632.5 сая төгрөгийн үнэ бүхий Ачаа, шуудан тээврийн үйлчилгээний барилга, Захиргааны барилга, Нисэх буудлын үйлчилгээний барилга;
- ТӨБЗГ-ын 2019 оны 382 дугаар тогтоолоор 96,090.4 сая төгрөгийн үнэ бүхий Ангaрын барилга, 20,640.8 сая төгрөгийн үнэ бүхий Ангaрын байгууламж, 241.3 сая төгрөгийн өртөгтэй УБОУШНБ-д байрлах Монгол-Японы дурсгалын хөшөө;
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комиссын дүгнэлт гарсан ИНЕГ-ын ажилчдын хүүхдүүдэд зориулсан 1,299.5 сая төгрөгийн өртөгтэй цэцэрлэгийн барилга;

- ИНЕГ-ын 12 ширхэг барилга байгууламжид 578.7 сая төгрөгийн капиталжуулалт хийж, үндсэн хөрөнгийн данс тус тус нэмэгдсэн.

Үндсэн хөрөнгийн зардал:

- ТӨБЗГ-ын 2021 оны 89 дүгээр тогтоолоор агентлагт бүртгэлтэй 67.9 сая төгрөгийн балансын үнэ бүхий суудлын автомашиныг Алтанбулаг боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албанд балансаас балансад шилжүүлсэн;
- ТӨБЗГ-ын 2021 оны 159 дүгээр тогтоолоор МИАТ ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой 2 нэр төрлийн нийт 1,172.2 сая төгрөгийн балансын үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгө, 71 нэр төрийн 40.8 сая төгрөгийн балансын үнэ бүхий эргэлтийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн;
- ТӨБЗГ-ын 2021 оны 313 дугаар тогтоолоор Ховд нисэх буудлын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 10.6 сая төгрөгийн балансын үнэ бүхий 2 ширхэг ачааны чиргүүлийг цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, Ховд аймгийн Авто тээврийн төвд балансаас балансад шилжүүлсэн;
- ТӨБЗГ-ын 2021 оны 325 дугаар тогтоолоор ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжгүй 1219 нэрийн 2,365.0 сая төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор акталж данснаас хассан.

Дуусаагүй барилга байгууламж данс нь улсын төсөв болон өөрийн хөрөнгө оруулалтаар хийсэн Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилгын ажлын гүйцэтгэл, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, улсын комисс хүлээж аваагүй, мөн өөрийн хөрөнгөөр хийсэн Спорт цогцолборын барилгын ажил дуусаж, улсын комисс хүлээн авсан боловч Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэр гараагүйгээс 28,514.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

- ИНУТ, УБОУШНБ барих төслийн нэгжид ашиглаж байсан 136.2 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн авсан боловч балансад бүртгэж аваагүй;

- Сүхбаатар аймаг дахь Баруун-Урт нисэх буудалд үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 142 ширхэг хөрөнгө бүртгэлтэй;

- Ховд аймаг дахь нисэх буудлын байгууллагын ажилчдын орон сууцанд хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон ажилчид амьдарч байгаа бөгөөд байр эзэмшиж байгаа ажилчидтай гэрээ байгуулаагүй;

- Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудалд 2021 онд БОАЖЯ-ны сайдын багцаас хийсэн зорчигчийг угтах заалны засварын ажлыг хүлээж авсан боловч бүртгэлд тусгаагүй.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны үлдэгдэл 30,176.8 сая төгрөг болж, 12,022.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр дүн	8,979,978.8	6,707,228.3	(2,272,750.5)
Өглөг	8,852,153.3	6,670,853.8	(2,181,299.5)
Урьдчилж орсон орлого	127,825.5	36,374.5	(91,451.0)
Урт хугацаат өр төлбөр дүн	9,174,178.9	23,469,575.3	14,295,396.5
Хойшлогдсон татварын өглөг	2,489,831.0	3,066,802.8	576,971.7
Урьдчилж орсон орлого /ХО/	6,684,347.8	20,402,772.6	13,718,424.7
Дүн	18,154,157.7	30,176,803.6	12,022,645.9

Эх сурвалж: ИНЕГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд гадаадын 33 авиа компанийн 1,599.6 сая төгрөгийн навигацийн төлбөрийн барьцаа, 1,510.2 сая төгрөгийн навигацийн төлбөрийн илүү төлөлт, 2,987.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлын барьцаа, 287.9 сая төгрөгийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, 97.2 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөг, 156.6 сая төгрөг хувь хүмүүст өгөх өглөг тус тус эзэлж байна.

Нийт өр төлбөрөөс 339.8 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн, тооцоо нийлж баталгаажуулаагүй, хөрөнгө оруулалтын ажлын үлдэгдэл барьцаа хөрөнгийн үлдэгдэл байршсан байна.

Хойшлогдсон татварын өглөг дансны үлдэгдэлд санхүү болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүгээс үүссэн 2,489.8 сая төгрөг, валютын бодит болон бодит бус ханшийн зөрүү 594.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 20,402.8 сая төгрөг болж, 13,718.4 сая төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан хөрөнгийн санхүүжилтээр хийсэн үндсэн хөрөнгийг орлогоор бүртгэж, тайлант хугацааны элэгдлийн зардлын дүнгээр орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал 2 байгууллагын 4.9 сая төгрөгийн өглөгийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,000,373.9 сая төгрөг болж, 70,091.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,947,351,547.0	1,972,186,690.9	24,835,143.9
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	2,378,109.9	2,001,019.6	(377,090.3)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	30,206,863.3	30,206,863.3	-
Хуримтлагдсан үр дүн	90,528,711.7	(4,020,712.0)	(94,549,423.7)
Дүн	2,070,465,232.0	2,000,373,861.8	(70,091,370.1)

Эх сурвалж: ИНЕГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 70,091.4 сая төгрөгөөр буурсан нь БНХАУ-ын Засгийн газрын тусламжаар ирсэн газрын үйлчилгээний тусгай зориулалттай 8 тээврийн хэрэгсэл, 1 тоног төхөөрөмжийг хойшлогдсон орлогоор бүртгэж, тайланд оны 320.2 сая төгрөгийн элэгдлийн зардлаар хорогдуулж, ТӨБЗГ-ын 2019 оны 382 дугаар тогтоолоор шилжиж ирсэн 1,264,630.6 сая төгрөгийн хөрөнгөд 34,833.1 сая төгрөгийн элэгдлийн зардал, 5,986.7 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийн татварын зардал төлж, 10,386.0 сая төгрөгийн авлагыг бууруулан өмнөх үеийн үр дүнд бүртгэснээс гадна тайлант үеийн алдагдал нөлөөлжээ.

3.5.8 Орлогын данс

Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын 2021 оны “Иргэний нисэхийн үндэсний төвийн 2021 оны орлого, зарлагын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/161/182 дугаар хамтарсан тушаалаар ИНЕГ болон түүний харьяа үйлдвэрлэлийн албадын 2021 оны нийт орлогыг 237,464.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 162,538.5 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Хүснэгт 8. Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт (+), Бууралт (-)
Навигацийн орлого	229,257,827.0	186,081,021.7	(43,176,805.3)
Туслах үйл ажиллагааны орлого	1,583,481.6	2,469,837.9	883,356.3
Бусад орлого	6,622,816.0	5,803,941.2	(818,874.8)
Дүн	237,464,124.6	194,354,800.8	(43,109,323.8)

Орлогын гүйцэтгэлээр 186,081.0 сая төгрөгийн навигацийн орлого, 2,189.9 сая төгрөгийн буулт, хөөрөлтийн орлого, 279.9 сая төгрөгийн зорчигч үйлчилгээний орлого, 340.4 сая төгрөгийн хүүгийн орлого, 5,463.5 сая төгрөгийн бусад орлого нийт 194,354.8 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн буюу 18.2 хувиар орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого батлагдсан төсвөөс 43,176.8 сая төгрөгөөр, бусад орлого 818.9 сая төгрөгөөр буурсан нь нислэгийн тоо 68715 болж, хэвийн үеийн нислэгтэй харьцуулахад 48.6 хувиар буурсантай холбоотой байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын улсын төсөвт төвлөрүүлэх 2021 оны навигацийн орлогыг 122,878.4 сая, ногдол ашгийг 414.9 сая төгрөгөөр төлөвлөн баталсныг бүрэн төвлөрүүлсэн байна.

3.5.9 Зардлын данс

Тайлант оны зардлын төлөвлөгөөг 162,538.5 сая төгрөгөөр баталснаас нийт зардлын гүйцэтгэл 129,069.4 сая төгрөг буюу 79.4 хувьтай байгаа нь дараах зардлын хэмнэлтээс шалтгаалсан байна.

Монгол Улсын Засгийн газар болон Улсын онцгой комиссын тогтоол шийдвэрээр хилийн хориг тавьж, нислэг түр зогссоны улмаас баталсан төлөвлөгөөнөөс хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 85.1 хувиар буюу 1,294.3 сая, гадаадад суралцагсдын зардлыг 69.4 хувиар буюу 1,380.2 сая, улсын мэдээллийн маягт хэвлэх зардлыг 64.4 хувиар буюу 20.2 сая, мэдээлэл сурталчилгааны зардлыг 62.4 хувиар буюу 55.1 сая, хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас 90.2 хувиар буюу 812.0 сая, гадаад албан томилолтын зардлыг 65.2 хувиар буюу 99.0 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 51.0 хувиар буюу 3,901.8 сая төгрөгийг тус тус дутуу зарцуулсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны төсвийн төслийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 5,593.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2,539.6 сая төгрөгөөр буюу цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 1,942.4 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 14.7 сая, хангамж, бараа материалын зардлыг 29.7 сая, нормативт зардлыг 35.8 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 10.1 сая, томилолт, зочны зардлыг 39.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 30.8 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 72.3 сая төгрөгөөр тус тус бууруулж, 3,053.6 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,053.6 сая төгрөгийн санхүүжилт олгосноос урсгал үйл ажиллагаанд 2,982.7 сая төгрөгийг зарцуулж, 70.9 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,982.7 сая төгрөг буюу 97.7 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 40.7 сая, байр ашиглалттай холбоотой зардлыг 13.4 сая, нормативт зардлыг 7.8 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 6.5 сая төгрөгөөр дутуу зарцуулсан буюу Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэх 3,053.6 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэлийг 70.9 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь үндсэн үйл ажиллагааны зардлыг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
	Код	Нэр				
1	72101	Иргэний нисэхийн ерөнхий газар (агентлаг)	3,053,592.9	2,982,700.6	70,892.3	97.7
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,879,788.3	2,808,896.0	70,892.3	97.5
1.2	80509	ОУ-ын байг-ын гишүүнчлэл хураа	173,804.6	173,804.6	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

ИНЕГ-ын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 116 арга хэмжээг үнэлж, 2 арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх боломжгүй, бүрэн буюу 100.0 хувийн хэрэгжилттэй 86 арга хэмжээ, 90.0 хувийн хэрэгжилттэй 12 арга хэмжээ, 70.0 хувийн хэрэгжилттэй 10 арга хэмжээ, 50.0 хувийн хэрэгжилттэй 4 арга хэмжээ, 30.0 хувийн хэрэгжилттэй 2 арга хэмжээ буюу 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн дундаж үнэлгээ 91.7 хувьтай, өмнөх оны үнэлгээнээс 4.3 хувиар өссөн байна.

3.8 Аудитын гол асуудал

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2021 оны А/124 дүгээр тушаалаар Татварын багц хууль болон нягтлан бодох бүртгэлийн маягт хөтлөх аргачлал, Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж баталсан байна.

3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээлэл байршуулахаас 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, тушаал шийдвэртэй холбоотой 2.0 сая төгрөгийн мэдээллийг ил тод мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д *“тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”*, 6 дугаар зүйлийн 6.4.5-д *“цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”*, 6.4.8-д *“бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”*, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны *“Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”* 29 дүгээр тогтоолын холбогдох заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, тогтоосон хуулийн хугацаанд ил тод байршуулах албан шаардлага хүргүүлэх

Аудитын илрүүлэлт:

- ИНУТ шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нийт 4196 мэдээлэл байршуулахаас 42 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээлэл, 246.3 сая төгрөгийн тушаал шийдвэрийг байршуулаагүй;
- Баянхонгор аймаг дахь нисэх буудал шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 9 гүйлгээ буюу 36.9 сая төгрөгийн гүйлгээ дутуу байршуулсан;
- Сүхбаатар аймаг дахь Баруун-Урт нисэх буудал шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, 13.7 сая төгрөгийн 2021 оны А/322 тушаалыг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн;
- Буянт-Ухаа Олон улсын нисэх шилэн дансны цахим хуудсанд 16 төрлийн 9,032.3 сая төгрөгийн 140 мэдээ ил тод байршуулахаас 1,041.2 сая төгрөгийн 3 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн;
- Дорнод аймгийн Чойбалсан нисэх буудал шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш 41.4 сая төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдөр баталсан “Иргэний нисэхийн үндэсний төвийн 2021 оны худалдан авах ажиллагааны тодотгол төлөвлөгөө”-ний дагуу урсгал зардал, өөрийн орлогын хөрөнгөөр нийт 62,462.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, тайлант онд санхүүжүүлэх 27,222.4 сая төгрөгийн 128 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Дэлхий нийтэд тархсан “Ковид-19” цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан 2,667.4 сая төгрөгийн 20 төсөл, арга хэмжээг хэмнэлтийн горимд шилжүүлэн хойшлуулахаар шийдвэрлэж, 24,555.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 108 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж ажиллажээ.

Тус газар нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд шинээр гэрээ байгуулан хэрэгжүүлэх 108, он дамжин хэрэгжих 19 төсөл, арга хэмжээг тусгасан байна. Тайлант онд нийт 14,250.4 сая төгрөгийн 74 төсөл, арга хэмжээний ажлыг хүлээн авч, гэрээ дүгнэн бүрэн хэрэгжүүлсэн, 8,336.9 сая төгрөгийн 19 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулж, он дамжин хэрэгжиж байна. Тендер зарласан боловч амжилтгүй болсон 1,127.8 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээ байна.

Тендер шалгаруулалтыг дүгнэн үзэхэд гэрээ дүгнэж, ажил хүлээн авч бүрэн хэрэгжсэн 74 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 69.0 хувь, гэрээ байгуулсан боловч ажил хүлээн авч, гэрээ дүгнээгүй, он дамжин хэрэгжих 19 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 13.5 хувь, амжилтгүй болсон, гэрээ байгуулаагүй 7 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 8.1 хувь, гэрээ байгуулж амжилттай болсон 3, тендер зарласан 5, нийт гэрээ байгуулсан 101 төсөл, арга хэмжээ буюу 85.3 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Илрүүлэлт: Өмнөх аудитаар өгсөн 2021 оны 473/A0170067 дугаар Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилга угсралтыг ажлыг гүйцэтгэсэн Үүрэг трейд ХХК-д хамаарах 15,388.2 сая төгрөгийн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй, үүнтэй холбоотой 2011 онд байгуулсан гэрээний үүргийн биелэлтийн алданги 664.2 сая, мөн Улсын комисс хүлээж аваагүй тул сүүлийн 3 жилд 958.6 сая төгрөгийн ашиглалтын зардал төлж, улсын төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7-д *"агентлагийн төсвийг тогтоосон журмын дагуу захиран зарцуулах"*, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4-д *"худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах"*, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т *"Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүрэг биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно"*, ИНЕГ болон "Үүрэг трейд" ХХК-ийн 2019 оны ИНЕГ/ТББ/БУ-47/10/93-34/18-63/19 дүгээр гэрээний 1 дүгээр хэсэгт *"... барилга угсралтын ажлыг 2019 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор дуусгана. 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Техникийн болон Улсын комисст хүлээлгээн өгнө"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Барилга байгууламжийн улсын комиссын дүгнэлт гаргуулж, ашиглалтад оруулах, гэрээний алданги болон ашиглалтын зардлыг гүйцэтгэгч компаниас гаргуулах, хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

Харьяа байгууллагуудад илэрсэн нийцлийн аудитын асуудлаар нийт 175.4 сая төгрөгийн 6 зөрчил илрүүлснээс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд зөрчлийг арилгах 2 албан шаардлага, зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлж, 175.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг өгсөн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтуудтай, худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох заавар, журамтай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Аудитын илрүүлэлт:

- ИНҮТ санхүүгийн програмын хөгжүүлэлт, тохируулгыг тухай бүр хийдэггүй, програмын хэрэглэгчийн эрхийн хязгаарлалтын хяналт сул, санхүүгийн мэдээллийн аюулгүй байдал, тайлант үеийн хаалт, санхүүгийн тайлан, тодруулгын дүн буруу татагдах алдаа давтагдан гарч байна;

- Ховд аймаг дахь нисэх буудал нь тайлант онд шатахуун худалдан авахдаа холбогдох хуульд заасан ажиллагааны журам мөрдөөгүй, тендерийн урилга нээлттэй мэдээлснийг нотлох баримтгүй, 103.4 сая төгрөгийн шууд гэрээ байгуулсан байна;

- Ховд аймаг дахь нисэх буудал нь худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй 72.0 сая төгрөгийн шууд гэрээ байгуулсан, нүүрсний тээвэр хийгдээгүй аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авсан, эд хариуцагчийн нэрээр мөнгө гаргаж нүүрс авсан байна.

3.10 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,375.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 50.6 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 1,214.8 сая төгрөгийн зөрчилд 16 албан шаардлага хүргүүлж, 109.9 сая төгрөгийн зөрчилд 13 зөвлөмж өгсөн хэрэгжилт 89.6 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 10. Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тогтоосон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	50,600.0	2	50,600.0	-	-	100.0
Албан шаардлага	16	1,214,800.0	11	1,003,589.0	5	211,211.0	68.7
Зөвлөмж	13	109,900.0	13	109,900.0	-	-	100.0
Нийт дүн	31	1,375,300.0	27	1,164,089.0	5	211,211.0	89.6

Төрд учруулсан хохирлыг буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх 82.2 сая төгрөгийн албан шаардлагад төлбөрийн акт тогтоож, гадаадад суралцагчдын болон барилга угсралтын ажлын гэрээний үүргийн биелэлт хангалтгүй, авлага барагдуулалттай холбоотой албан шаардлагын хэрэгжилт удаашралтай тул хариуцлага тооцох албан шаардлага тус тус хүргүүлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Иргэний нисэхийн салбарын хэмжээний төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт, гүйцэтгэлийг Иргэний нисэхийн үндэсний төвд зохион байгуулан ажилладаг бөгөөд ИНЕГ-т аудитыг хийж гүйцэтгэсэн цаг хугацааны хязгаарлагдмал нөхцөл байдал, хамрах хүрээнээс шалтгаалан худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд түүврийн горим, сорил хэрэгжүүлсэн хэдий ч хангалттай, зохистой нотолгоо олж авах боломжгүй байгаа тул Төрийн аудитын байгууллагаас эрсдэлийн аудит оруулах шаардлагатай гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,907.6 сая төгрөгийн 23 алдаа, зөрчил илэрснээс, 1,162.6 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 494.9 сая төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,085.0 сая төгрөгийн 11 зөрчлийг арилгах албан шаардлага, зөрчлийг давтан гаргасан 2,162.2 сая төгрөгийн 3 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 2.9 сая төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 3,745.0 сая төгрөг нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдал 2,883.5 сая төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

4.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 3 төрийн өмчит аж ахуйн нэгж, 2 алба, 13 аймгийн нисэх буудал нийт 18 санхүүгийн тайланг нэгтгэснээс 14 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 алба, газрыг түүвэрт хамруулсан, Булган, Дундговь аймаг дахь нисэх буудал болон Аюулгүй байдал хамгаалалтын алба санхүүгийн тайлан гаргадаггүй тул аудитад хамрагдаагүй байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 11, “Хязгаарлалттай” 2, “Татгалзсан” 1 дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудад нийт 247,181.8 сая төгрөгийн 38 алдаа, зөрчил илрүүлснээс 246,541.8 сая төгрөгийн 8 алдааг аудитын явцад залруулж, 21.7 сая төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 356.3 сая төгрөгийн 10 зөрчлийг арилгах албан шаардлага, зөрчлийг давтан гаргасан 2 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 261.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 14 зөвлөмжийг хүргүүллээ.

4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 1,162.6 сая төгрөгийн 2 алдааг залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн тайланд хуримтлагдсан ашиг, эздийн өмчийн дүнг 727.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Орлогын албан татварын зардлыг 435.3 сая төгрөгөөр хасах дүнгээр илэрхийлсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө", 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

4.2.2 Төлбөрийн акт

1. Өмнөх оны аудитаар төрд учруулсан 82.2 сая төгрөгийн хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.2-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төрд учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

2. Хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдэл 337.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-д "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Хөрөнгө оруулалтын ажлын үлдэгдэл төлбөрийг улсын төсөвт татан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

3. British airways компанийн B77W маягийн G-STBG регистрийн дугаартай 340 тонн хөөрөлтийн дээд хүндийн жинтэй агаарын хөлгийн жинг 240 тонн гэж оруулснаас агаарын навигацийн үйлчилгээний төлбөрийг 15,422.58 ам.доллар буюу 43.7 сая төгрөгөөр дутуу тооцон нэхэмжилж, навигацийн орлогыг дутуу бүрдүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1-т "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Иргэний нисэхийн ерөнхий газрын 2017 оны А/266 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх гадаадын агаарын тээвэрлэгчдийн агаарын хөлөгт үзүүлэх навигацийн үйлчилгээний үнэлгээний норм" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Дутуу тооцож нэхэмжилсэн навигацийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

4. Өмнөх оны аудитаар төрд учруулсан 31.4 сая төгрөгийн хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр Иргэний нисэхийн үндэсний төвд хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төрд учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

4.2.3. Албан шаардлага

1. Тайлант хугацаанд шүүхийн шийдвэрээр нэр бүхий 3 ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт 35.5 сая төгрөг олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т *"Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ"*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлж, байгууллагыг хохиролгүй болгох албан шаардлага өгөх

2. Чингис хаан банкны 2020 оны ГЗ/203 дугаар албан бичгээр дансны төлбөр тооцооны системийн доголдлоос хамаарч гүйлгээ хийх боломжгүй болсон тухай шийдвэр ирсэн тул зарцуулаагүй үлдэгдэл 2,767.0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө санхүүгийн эрсдэлд орсон байна.

Энэ нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7-д *"агентлагийн төсвийг тогтоосон журмын дагуу захиран зарцуулах"*, Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т *"Энэ хууль нь төсвийн байгууллага, түүний албан тушаалтан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарна"*, 5 дугаар зүйлийн 5.1.3-т *"санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"*, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтарсан тушаалд заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Чингис хаан банканд байршуулсан мөнгөн хөрөнгийг татан төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэх

3. ИНУТ-ийн санхүүгийн тайланд ИНЕГ-ын өмчлөлийн 225.1 сая төгрөгийн өртөгтэй 5 ширхэг орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.4-т *"Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:"*, 14.4.1-т *"аж ахуйн бүх ажил, гүйлгээ"*, 14.4.2-д *"бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"*, 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"*, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5.-д *"Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна. Уг төлбөр тухайн эд хөрөнгийг худалдан авах үнийн төлбөрт үл хамаарна"*, Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолын 3-д *"Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түрээсээр эзэмшүүлэх зорилго нь төрийн өмчийн ашиглалтыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ."* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Үл хөдлөх хөрөнгийг улсын бүртгэлийн гэрчилгээнд зааснаар ИНЕГ-ын санхүүгийн тайланд бүртгэх, төрийн өөрийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх албан шаардлага хүргүүлэх

4. ИНЕГ-ын санхүүгийн тайланд бүртгэлтэй 59,528 м.кв бүхий 3 газрын эзэмшлийн асуудал шийдэгдээгүйгээс шалтгаалан 2018 онд дахин үнэлгээнд хамрагдаагүй, балансын үнэ өртөггүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.4-т *"Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:"*, 14.4.1-т *"аж ахуйн бүх ажил, гүйлгээ"*, 14.4.2-д *"бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"*, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны "Аргачлал батлах тухай" 207 дугаар тушаалд заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд бүртгэлтэй газрыг дахин үнэлгээнд хамруулж, бодит үнэ цэнээр бүртгэх албан шаардлага хүргүүлэх

5. ИНУТ-ийн санхүүгийн тайланд бүртгэлтэй 98.3 сая төгрөгийн өртөгтэй 2 ширхэг орон сууц нэр бүхий 2 иргэний нэр дээр Улсын бүртгэлийн гэрчилгээтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:", 14.4.1-т "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 3-д "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно.", 4-д "Төрийн өмчийн эд хөрөнгөнөөс нэг удаагийн тэтгэмж, тусламж олгох журмыг Засгийн газраас тогтооно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг ИНЕГ-ын нэр дээр гаргуулах албан шаардлага хүргүүлэх

6. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчин 54.5 сая төгрөгийн ажлын хэсгийн нэмэгдэл, дүрэмт хувцас хэрэглэл, утасны хөнгөлөлт зэрэг бусад хэмнэж болох зардал зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1-т "Монгол Улсын 2021 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авч ажиллаж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад улс, орон нутгийн төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус даалгасугай", 1.4-т "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Монгол Улсын Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлэх

7. Гадаадын авиа компаниудаас 4,017.5 сая, дотоодын авиа компаниудаас авах 52.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн акт үйлдэх боломжгүй, мөн гадаадын авиа компаниудаас авах 2011 оноос үүссэн олон жилийн насжилттай, хугацаа хэтэрсэн найдваргүй болох магадлалтай 4,894.4 сая төгрөгийн авлагыг барагдуулах, эзэн холбогдогчийг тодруулах талаар ХЗДХЯ-д 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдөр хүсэлт хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8-д "Өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Олон жилийн насжилттай, эзэн холбогдогч нь тодорхойгүй, найдваргүй болох магадлалтай авлагыг барагдуулах талаар тухайн улсын шүүх хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлэх албан шаардлага хүргүүлэх

8. Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолоор тус газрыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг гэсэн статустай төрийн захиргааны байгууллагаар тодорхойлсон байтал Улсын бүртгэлийн гэрчилгээ нь ТӨААТҮГ, албан хаагчдын цалинг "Хөдөлмөрийн хөлсний суурь жишиг"-ээр олгодог, хөрөнгийн бүртгэл тодорхойгүй, улсын төсвөөс олгосон санхүүжилтэд УСНББОУС-ын дагуу санхүүгийн тайлан бэлтгэж гаргадаггүй байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт "Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийн жагсаалт", Засгийн газрын 2019 оны 275 дугаар "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай", Төсвийн

тухай хуулийн 54 дүгээр зүйлд “Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Хуулийн этгээдийн эд хөрөнгийн эрхийн байдал, хариуцлагын хэлбэрийг тодорхой болгож, цалин, урамшуулал, санхүүгийн тайлагнал, хөрөнгийн бүртгэлийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох албан шаардлага хүргүүлэх

9. Өмнөх аудитаар өгсөн 2021 оны 474/A0170067 дугаар албан шаардлагаас нэг суралцагчийн 7.0 сая төгрөгийн авлагыг шүүх хяналтын байгууллагад дахин хандаж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7-д “агентлагийн төсвийг тогтоосон журмын дагуу захиран зарцуулах”, Иргэний нисэхийн ерөнхий газрын 2019 оны А/289 дүгээр тушаалаар баталсан “Иргэний нисэхийн чиглэлээр суралцуулах журам”-ын 4.2-т “Иргэний нисэхийн чиглэлээр мэргэжлийн хүний нөөцийг сургаж, бэлтгэхдээ дараах үндсэн мэргэжлүүдээр бэлтгэнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Хууль, хяналтын байгууллагад дахин хандаж, авлагыг барагдуулж ажиллах, хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

10. Өмнөх оны аудитаар өгсөн 2021 оны 472/A0170067 дугаар албан шаардлагаас сургалтын журмын 4.2-д заасныг зөрчиж 122.0 сая төгрөгийг бүрэн төлж, Канад улсад нягтлан бодогчоор суралцагч сургуулиа төгсөөгүй 3 удаагийн сунгалт хийлгэсэн.

Мөн АНУ болон Австрали улсад суралцуулахаар нэр бүхий хоёр оюутны төлбөрт нийт 410.4 сая төгрөг төлсөн боловч 3 удаа сунгалт хийж, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй, үр ашиггүй зардал зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7-д “агентлагийн төсвийг тогтоосон журмын дагуу захиран зарцуулах”, Иргэний нисэхийн ерөнхий газрын 2019 оны А/289 дүгээр тушаалаар баталсан “Иргэний нисэхийн чиглэлээр суралцуулах журам”-ын 4.2-т “Иргэний нисэхийн чиглэлээр мэргэжлийн хүний нөөцийг сургаж, бэлтгэхдээ дараах үндсэн мэргэжлүүдээр бэлтгэнэ”, 7-д “Сургалтын үйл ажиллагаанд тавигдах хяналт, холбогдох баримт материалын зохицуулалт”, 9.2-т “ИНЕГ-ын захиргаа, хүний нөөц хариуцсан нэгж нь энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана”, Сургалтын гэрээний 3 дугаар зүйлд “Суралцагчийн эрх үүрэг”, Сургалтын гэрээний нэмэлт өөрчлөлтийн 4-т “сургалтын гэрээнд дахин нэмэлт өөрчлөлт оруулахгүй” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулж ажиллах, төсвийг үр ашигтай зарцуулах, холбогдох журамд сунгалтын талаар нэмэлт өөрчлөлт оруулах, хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

11. Харьяа Иргэний нисэхийн үндэсний төвд тайлант хугацаанд Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 183/ШШ2020/03075, 2021 оны 001/ХТ2021/00600 дугаар шийдвэрээр нийт 31.8 сая төгрөгийн ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг нэр бүхий гурван ажилтанд олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлж, байгууллагыг хохиролгүй болгох албан шаардлага өгөх

12. Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар залруулагдаагүй нийт 639.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 21.7 сая төгрөгийн 4 акт тогтоож, 356.3 сая төгрөгийн 10 албан шаардлага, зөрчлийг давтан гаргасан 2 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 261.9 сая төгрөгийн 14 зөвлөмж өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.11-д “төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 19 дүгээр зүйлийн 19.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион

байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Харьяа байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн алдаа, зөрчилд эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлд суурилсан төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 1039 ширхэг 950.9 сая төгрөгийн хөрөнгөнд дахин үнэлгээ хийгээгүй, арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6 дугаар зүйлд "Төрийн өмчийн эд хөрөнгийг акталж, данснаас хасах", 7 дугаар зүйлд "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: ТӨБЗГ-т ӨХБЗ-ийн шийдвэрийг хүргүүлж, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлэх, данс бүртгэлд тусгах

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 2 нэр төрлийн 2.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авч шууд зардалд бүртгэсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "жинхэнэ хэрэгжилтийн", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалд заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн шинжтэй тоног төхөөрөмжийг данс бүртгэлд зөв ангилж бүртгэх

3. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: ТӨБЗГ-ын 2019 оны 382 дугаар тогтоолоор УБОУНОШБ-ын 1,264,630.6 сая төгрөгийн хөрөнгө шилжиж ирсэнтэй холбоотойгоор ИНЕГ нь үл хөдлөх хөрөнгийн татварт 5,986.7 сая төгрөг төлж, 34,833.1 сая төгрөгийн тайлант хугацааны элэгдэл байгуулж бүртгэсэн нь санхүүгийн үр дүнгийн тайланд сөргөөр нөлөөлж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "жинхэнэ хэрэгжилтийн", Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-д "Агентлаг нь өөрт нь олгосон эд хөрөнгө болон хуульд заасны дагуу олсон орлогоороо бий болгосон эд хөрөнгийг хуульд заасан журмын дагуу эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: УБОУНОШБ-д болон нийт хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэн хүлээлгэн өгөх талаар ТӨБЗГ-т хандаж шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Аудитын санал дүгнэлт							Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:									
			Үүнээс:									Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
			Бүгд	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзах	Хамрагдаагүй	Түүвэрт	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ																					
1	Иргэний нисэхийн ерөнхий газар	АХГ-2022/04/НА-СТА-ТТЗ	1		1					21	4,267,589.9	2	1,162,532.6	4	494,856.3	9	445,084.0	3	2,162,207.0	3	2,910.0
Дүн			1	-	1	-	-	-	-	21	4,267,589.9	2	1,162,532.6	4	494,856.3	9	445,084.0	3	2,162,207.0	3	2,910.0
ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА																					
1	Иргэний нисэхийн үндэсний төв ААТҮГ	АХГ-2022/18/НА-СТА-ТӨА	1		1					9	246,586,982.8	3	246,425,264.6	1	10,589.9	2	151,128.3			3	-
2	Буянт-Ухаа ОУНБ	АХГ-2022/19/НА-СТА-ТӨА	1	1						2	106,276.1					2	106,276.1				
3	Холбоо, навигацийн ашиглалтын алба	АХГ-2022/20/НА-СТА-ТӨА	1						1	-	-										
4	ТӨААТҮГ Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын алба	АХГ-2022/21/НА-СТА-ТӨА	1						1	-	-										
5	Аюулгүй байдал хамгаалалтын алба	Санхүүгийн тайлан гардаггүй	1						1	-	-										
6	Иргэний нисэхийн ерөнхий газар ТӨААТҮГ Сэргээн засах амралт	АХГ-2022/22/НА-СТА-ТӨА	1				1			1	-						1		-		-
7	Иргэний нисэхийн ерөнхий газар Төрийн өмчит Баянхонгор аймаг дахь Нисэх буудал	БНА-2022/1/НА-СТА-ТӨҮГ	1	1						2	1,614.3									2	1,614.3
8	Иргэний нисэхийн ерөнхий газар Төрийн өмчит Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудал	БӨА-2022/04/НА-СТА-ТБОНӨААН	1	1						-	-										
9	Иргэний нисэхийн ерөнхий газар Төрийн өмчит Булган аймаг дахь Нисэх буудал	Санхүүгийн тайлан гардаггүй	1						1	-	-										
10	Иргэний нисэхийн ерөнхий газар Төрийн өмчит Говь-Алтай	ГАА-2022/01/-НА-СТА-ТӨҮГ	1	1						5	43,064.6	2	36,303.7			3	6,760.9				

**Иргэний нисэхийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

	аймаг дахь Нисэх буудал																				
11	Иргэний нисэхийн ерөнхий газар Төрийн өмчит Дорнод аймаг дахь Нисэх буудал	ДОА-2022/05/НА-СТА-ТӨА	1	1					-	-											
12	Иргэний нисэхийн ерөнхий газар Төрийн өмчит Дундговь аймаг дахь Нисэх буудал	Санхүүгийн тайлан гардаггүй	1				1		-	-											
13	Иргэний нисэхийн ерөнхий газар Төрийн өмчит Завхан аймаг дахь Нисэх буудал	ЗАА-2022/02/СТА-ТӨХК	1	1					-	-											
14	Иргэний нисэхийн ерөнхий газар Төрийн өмчит Өвөрхангай аймаг дахь салбар	ӨВА-2022/5/НА-СТА-ТӨА	1	1					-	-											
15	Иргэний нисэхийн ерөнхий газар Төрийн өмчит Өмнөговь аймаг дахь Нисэх буудал	ӨМА-2022/142/НА-СТА-УТҮГ	1	1					-	-											
16	Иргэний нисэхийн ерөнхий газар Төрийн өмчит Хөвсгөл аймаг дахь Нисэх буудал	ХӨА-2022/01/НА-СТА-ТӨА	1	1					2	46,245.8									2	46,245.8	
17	Иргэний нисэхийн ерөнхий газар Төрийн өмчит Ховд аймаг дахь Нисэх буудал	ХОА-2022/03/НА-СТА-ТӨА	1		1				8	317,334.0	-	-	3	11,158.2	1	92,092.6	-	-	4	214,083.2	
18	Иргэний нисэхийн ерөнхий газар Төрийн өмчит Хэнтий аймаг дахь Нисэх буудал	ХЭА-2022/01/НА-СТА-ТӨҮГ	1					1	-	-											
19	Иргэний нисэхийн ерөнхий газар Төрийн өмчит Сүхбаатар аймаг дахь Нисэх буудал	СБА-2022/01/НА-СТА-ТӨА	1					1	1	-									1	-	
20	Иргэний нисэхийн ерөнхий газар Төрийн өмчит Тосонцэнгэл аймаг дахь Нисэх буудал	ЗАА-2022/01/СТА-ТӨХК	1	1					3	80,275.6	3	80,275.6									
21	Иргэний нисэхийн ерөнхий газар Төрийн өмчит Увс аймаг дахь Нисэх буудал	УВА-2022/06/НА-СТА-ТӨА	1	1					-	-											
ДҮН			21	11	2	-	1	3	4	33	247,181,793.2	8	246,541,843.9	4	21,748.1	8	356,257.9	1	-	12	261,943.3
НИЙТ ДҮН			22	11	3	-	1	3	4	54	251,449,383.1	10	247,704,376.5	8	516,604.4	17	801,341.9	4	2,162,207.0	15	264,853.3

5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
					Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Иргэний нисэхийн ерөнхий газар	АХГ-2022/04/НА-СТА-ТТЗ	2	-	-	-	-	-	2	-	-	-	-	-
2	Иргэний нисэхийн үндэсний төв ААТҮГ	АХГ-2022/18/НА-СТА-ТӨА	1	-									1	-
3	Буянт-Ухаа ОУНБ	АХГ-2022/19/НА-СТА-ТӨА	1	-							1	-		
4	Иргэний нисэхийн ерөнхий газар Төрийн өмчит Баянхонгор аймаг дахь салбар	БНА-2022/1/НА-СТА-ТӨҮГ	1	-					1	-				
5	Иргэний нисэхийн ерөнхий газар Төрийн өмчит Дорнод аймаг дахь салбар	ДОА-2022/05/НА-СТА-ТӨА	1	-					1	-				
6	Иргэний нисэхийн ерөнхий газар Төрийн өмчит Сүхбаатар аймаг дахь салбар	СБА-2022/01/НА-СТА-ТӨА	1	-									1	-
НИЙЦЛИЙН АУДИТЫН ЗӨРЧЛИЙН НИЙТ ДҮН			7	-	-	-	-	-	4	-	1	-	2	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2022 оны 03 дугаар сарын 25 № 152/АО160069
АХТ-2022/22/НА-СТА-ТТЗ
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

British airways компанийн В77W маягийн G-STBG регистрийн дугаартай 340 тонн хөөрөлтийн дээд хүндийн жинтэй агаарын хөлгийн жинг 240 тонн гэж оруулснаас агаарын навигацийн үйлчилгээний төлбөрийг 15,422.58 ам.доллар буюу 43,740,921.00 төгрөгөөр дутуу тооцон навигацийн орлогыг бүрдүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Иргэний нисэхийн ерөнхий газрын 2017 оны А/266 дугаар тушаалаар баталсан "Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх гадаадын агаарын тээвэрлэгчдийн агаарын хөлөгт үзүүлэх навигацийн үйлчилгээний үнэлгээний норм"-д заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дутуу төвлөрүүлсэн навигацийн орлого 43,740,921.00 /дөчин гурван сая долоон зуун дөчин мянга есөн зуун хорин нэгэн/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга С.Мөнхнасан, ерөнхий нягтлан бодогч Х.Баярмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9019120396

2022.10.10.20\Bichig_Khereg\Akt\2022\0325 Auditin 2 Gazar-86.Docx

0001090362



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2022 оны 03 дугаар сарын 25 № 153/АО160064

Улаанбаатар хот

АХГ-2022/22/НА-СТА-ТТЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдэл 337,470,258.00 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2 "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.3-д заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Барьцаа дансны үлдэгдэл 337,470,258.00 /гурван зуун гучин долоон сая дөрвөн зуун далан мянга хоёр зуун тавин найман/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга С.Мөнхнасан, ерөнхий нягтлан бодогч Х.Баярмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

